МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт
манлайлна

САЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЭНТРЕПРЕНЁР

MNCA.MN

2025.11

БАРИЛГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ 1-3 ХОНОГИЙН ДОТОР АВАХ БОЛОМЖТОЙ



МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН ХИМОН КОНСТРАКШН КОМПАНИЙН ЗАХИРАЛ Ш.ЭНХТӨРД МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

INTERNATIONAL FEDERATION OF ASIAN AND WESTERN PACIFIC CONTRACTORS' ASSOCIATIONS

INTERNATIONAL FEDERATION OF CONSULTING ENGINEERS

МБҮА

+976-7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци

РЕДАКЦИ

ХЯНАН ТОХИОСОН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.ЭНХБААТАР

НЭГТЭЛ РЕДАКТОР:
Б.ТӨВШИНБОЛОР

ОРОЛЦСОН:
АЖЛЫН АЛБА

АГУУЛГА

НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ, САЛБАРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, НОРМ, ДҮРЭМ ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР
- ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
- ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭХ

НИЙГМИЙН ҮНЭ ЦЭНИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- ХОТ СУУРИН ГАЗАР, ДАГУУЛ ХОТУУДЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД
- ДЭД БҮТЭЦ, ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД

ГИШҮҮНЧЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ГРАФИК, ҮЗҮҮЛЭЛТ
- ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАА САЛБАРЫН БОДЛОГО, СУДАЛГААГААР ХАНГАЖ АЖИЛЛАЖ БАЙГАА БАЙДАЛ
- ГИШҮҮДИЙГ СУРГАЛТ, ТУРШЛАГА СУДЛУУЛАХ АЯЛАЛ, ВОРКШОП АРГА ХЭМЖЭЭНД ХАМРУУЛСАН БАЙДАЛ
- ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЭР СУРТАЛЧИЛСАН НЬ

МБҮА

SINCE 2009

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

Зөв зүгт Манлайлна



МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

21 АЙМАГТ АССОЦИАЦИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙГ байгуулж эхэллээ

АССОЦИАЦИ НЬ САЛБАР ЗӨВЛӨЛҮҮДТЭЙ ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАНА.

- Сургалт, зөвлөгөөн
- Туршлага солилцоо
- Төслүүд, хөрөнгө оруулалт
- Шударга өрсөлдөөн, стандартын хяналт

7011 1515 info@mnca.mn

www.mnca.mn



БАЯН-ӨЛГИЙ **ХОВД** **ДАРХАН-УУЛ**

Аймгуудад САЛБАР ЗӨВЛӨЛ-ийг байгуулаад байна.

I.Нөлөөллийн үйл ажиллагааны зорилтын хүрээнд

www.mnca.mn

МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД ХИМОН КОНСТРАКШН ХХК-ИЙН ЗАХИРАЛ, МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН Ш.ЭНХТӨРД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Монгол Улсын ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН гэх алдрыг хүртсэн МБҮА ТББ-ын Гишүүн Ш.Энхтөрийн гавьяатын мялаалгын арга хэмжээнд МБҮА ТББ-ын Хүндэт ерөнхийлөгч Д.Цэрэнжигмэд, Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, Дэд ерөнхийлөгч С.Нямдаваа, Б.Хүрэлхүү, Б.Чимэгцэцэг, Д.Энхтөр, Гүйцэтгэх захирал Г.Батсүх, Удирдах зөвлөлийн гишүүн Ш.Үнэнбат нар хүрэлцэн очиж Нийт гишүүдийнхээ өмнөөс хүндэтгэл үзүүллээ.

Химон констракшн ХХК нь Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-д 2009 оноос хойш Гишүүн байгууллагаар элсэж өнөөдрийг хүртэл барилгын салбарын хууль эрх зүй, бодлого, хөгжлийн зүгт нэгэн баг болж ажиллаж байгаа анхны Гишүүн байгууллагуудын нэг билээ.

1998 Бридж констракшн ХХК-д инженерээр орохдоо тоосго үүрэн, шавар зуурч, будагчны туслах, өрлөгчин, бетон арматурчин, мужаан гээд бүх дамжлага дээр 6 сар гаруй ажиллаж яг нэг жилийн дараа компанийхаа Ерөнхий инженер болж байсан Ш.Энхтөр захирал 2006 онд Япон улсад магистр хамгаалж ирээд компани үүсэн байгуулж байсан бөгөөд Японы олон төсөл хөтөлбөрүүд дээр ажиллахаас гадна барилгын салбарт олон техник технологийг нэвтрүүлэн ажиллаж байна.

1999 Барилгын салбарт 27 жил ажиллах хугацаанд 500 гаруй инженер, техникийн ажилтныг сургаж, давхардсан тоогоор 1000 гаруй хүнийг ажлын байраар ханган эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсныг үнэлж 2025.07.10-ны өдөр Химон констракшн ХХК-ийн захирал Ш.Энхтөрд Монгол Улсын Гавьяат барилгачин хэмээх шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх гардуулсан юм.









БАРИЛГЫН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААР ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТӨВИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ

МБҮА ТББ нь барилга, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгө, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт, зураг төсөл, архитектурын чиглэлийн 200 гаруй барилгын гишүүддээ үйлчилдэг, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэдэг үндэсний бүтээн байгуулагчдын хамгийн том нэгдэл болох төрийн бус байгууллага билээ. Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ийн Салбарын бодлого, төлөвлөлт,



судалгааны хэлтсийн дарга М.Энхбаатар барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн шинэ суурь нөхцөл, шаардлага болоод 2025.09.05-ны өдрөөс Зөвшөөрлийн нэгдсэн систем **license.mn** цахим системээр авдаг болсон тухай болон барилгын зураг төслийн магадлал, салбарын хяналтын тогтолцооны талаар мэдээлэл өглөө.

Харин Барилгын Төсөвчдийн Холбоо ТББ-ын УЗ-ын дарга Ү.Банди төсөв зохиох онол, арга зүй, түүний хэрэглээний талаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-ийн газрын дарга болоод мэргэжилтнүүдэд мэдээлэл, танилцуулга хийлээ.



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛИЙН ХҮСЭЛТ ГАРГАХ СИСТЕМ ӨӨРЧЛӨГДСӨНТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ТАЛААР ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ, АТГ МБҮА ТББ ХАМТРАН АЖИЛЛАНА



“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох” үйл ажиллагааг МБҮА ТББ нь салбарын түншлэгч ТББ-уудыг төлөөлөн




БХБЯ, ХББОСЯ-тай 5 дахь удаа гэрээ байгуулан ажиллаж байна.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн шинэ суурь нөхцөл, шаардлага болоод 2025.09.05-ны өдрөөс Зөвшөөрлийн нэгдсэн систем license.mn цахим системээр авдаг болсон тухай Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны Хэлтсийн дарга Д.Батзориг, АТГ-ын УССГХ-ийн комиссар С.Баярцэцэг, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар, Тусгай зөвшөөрлийн хэлтсийн дарга Ж.Өсөхбаяр нар санал солилцлоо.

“Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулах” үйл ажиллагааг цахим платформуудтай холбогдсоноор Монгол Улсын тогтолцоо, хууль эрх зүйн ба бизнесийн орчныг боловсронгуй болгож, хүнд суртал, авлигатай тэмцэх зорилтын хүрээнд цахим, ил тод, нээлттэй, хүнээс хараат бус тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байгаа ба үүнийг олон нийтэд сурталчлах, мэдээллэх тал дээр хамтран ажиллахаар болов.


2.НИЙГМИЙН ҮНЭ ЦЭН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



www.mnca.mn

МБҮА ТББ-иас сар бүр хүргэдэг **"ИХ БАРИЛГА-ТООНЫ ХЭЛЭЭР"** цуврал контентын энэ удаагийн дугаарыг ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА сэдвийн хүрээнд бэлтгэснийг та бүхэндээ хүргэж байна.
https://shorturl.at/nYNKB





ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

АЖЛЫН АЛБАНЫ БҮАТЗХ-ИЙН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН ТОЙМ

БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 800 гаруй хуулийн этгээд, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав. БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд тавих нөхцөл, шаардлагын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг license.mn-ээр хүссэн **216**-н хуулийн этгээдийн хүсэлт, материалыг баталгаажуулж, ХББОСЯ-нд 2025.10.31-ны өдөр албан бичиг болон цахимаар илгээж ХББОССайдын 2025.11.19-ний өдрийн 249 дугаар тушаалаар баталгаажуулан ирүүлсэн.



ХББОССайдын 2025 оны 124 дүгээр тушаалын дагуу “Зөвшөөрлийн цахим систем”-д шилжих ажлыг зохион байгуулан 2025.09.05-ны өдрөөс эхлэн “LICENSE.MN”-ээр хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж эхэлсэн.

Тайлант хугацаанд license.mn-ээр хүсэлт гаргасан БУ:123, ЗТ:23, ӨБ:5 нийт **151**-н хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулан ажиллав.
Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор license.mn-ээр хүсэлт гаргасан **288** хуулийн этгээдийн хүсэлт хянагдаж, **1** удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар **216** хуулийн этгээдийн хүсэлтийг ХББОССайдын тушаалаар баталгаажуулсан. Дараагийн ээлжинд **151** хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулан ХББОСЯ-нд хүргүүлэхээр ажиллаж байна.


БҮАТЗ-н хүсэлт гаргасан **22** хуулийн этгээдийн хүсэлт хянагдахаар хүлээгдэж байгаа бол **56** хуулийн этгээдэд улсын тэмдэгтийн хураамж үүсгэсэн бөгөөд төлөлт хийгдсэний дараа баталгаажуулахаар хүлээгдэж байна.

Үүнээс: №2 дугаар баталгаажуулалтаар Барилга угсралт **181**, Зураг төсөл **31**, Өргөх байгууламж **4** хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулав.


№3 дугаар баталгаажуулалтаар Барилга угсралт **123**, Зураг төсөл **23**, Өргөх байгууламж **5** хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулан ХБББОСЯ-нд хүргүүлэхэд бэлтгэн ажиллаж байна.

Хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг шалгаж **59** хуулийн этгээдийн материалыг шаардлага хангаагүйн улмаас буцаасан.

Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих нөхцөл, шаардлагын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн **216** хуулийн этгээдийн хүсэлтийн материалыг хянаж **952** инженер, техникийн ажилтнуудын бүртгэлд хяналт тависан бол **151** хуулийн этгээдийн хүсэлтийн материалыг хянаж **802** инженер, техникийн ажилтнуудын бүртгэлд хяналт тависан.



- БҮАТЗ-ийг ээмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон ХБББОССайдын 1 удаагийн тушаалын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын opendata.burtgel.gov.mn-д БУ: 5369, ЗТ: 1072, ӨБ: 191 хуулийн этгээдийн нийт **6521** мэдээллийг нээлттэй байршуулах хүсэлтийг хүргүүлэв.
- БҮАТЗ-тэй хуулийн этгээдийн мэдээллийн санд “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 5276, ЗТ: 1112, ӨБ: 192 нийт **6580** хуулийн этгээдийн мэдээллийг үүсгэн www.mcis.gov.mn-ын нээлттэй байршуулав.
- Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам (ЦХХХЯ)-ны тусгай зөвшөөрлийн цахим системд тайлант хугацаанд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тушаалаар гарсан БУ: 181, ЗТ: 31, ӨБ: 4 нийт **216**-н хуулийн этгээдийн мэдээллийг хүргүүлсэн.
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын тушаалыг үндэслэн **145**-н хуулийн этгээдтэй гэрээг байгуулж, “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох” тухай хуулийн дагуу **154.800.000** төгрөгийн хураамжийг төвлөрүүлэв.
- License.mn зөвшөөрлийн цахим системээр хүсэлт ирүүлсэн **151-н** хуулийн этгээдэд улсын тэмдэгтийн хураамж үүсгэн **193.250.000** төгрөгийн хураамжийг төвлөрүүлэв.
- ХБББОССайдын тушаалаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авч, гэрээ байгуулах тухай нийт **329** хуулийн этгээдэд масс мессежээр мэдээлэл хүргүүлэв.
- Зөвшөөрлийн нэгдсэн систем /https://license.mn//-д шилжсэнтэй холбоотой call center-н бүтэцийг өөрчилөн шинэ бүтэц зураглан шинээр алхамт нэмэв. Холбогдсон үйлчилгээ авах хэрэглэгчийн залгасан дугаарт SMS-ээр хүссэн мэдээллийг нь явуулдаг болгосон. Мөн fb.com дээр chatplugin асааж chatbot ажиллагаанд оруулж холбогдох мэдээллийг тогтмол шинэчлэж байна. Барилгын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нэг дороос авах боломжтой цахим хуудсыг хөгжүүлэн цаашид холбогдох мэдээллийг төрөлжүүлэн ажиллаж байна.
- Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдэд зориулсан



– ХАБЭА-н сургалтанд зориулж Тусгай зөвшөөрөл олголтын өнөөгийн байдал болон Зөвшөөрлийн цахим системд шилжсэнтэй холбоотой зөвлөгөө мэдээллийг өгч ажиллав.



МБҮА

SINCE 2009

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ


Зөв зүгт Манлайлна



www.mnca.mn

3.ГИШҮҮНЧЛЭЛ УЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХУРЭНД

ТӨВИЙН БҮСИЙН БАРИЛГЫН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам ХДархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар, Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар-тай хамтран төвийн бүсийн барилгын салбарын удирдах ажилтнуудад зориулан БАРИЛГЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ХАБЭА-ын сургалт ба “БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛИЙН ХҮСЭЛТ ГАРГАХ ЗААВАР ЗӨВЛӨГӨӨ”-сургалтыг 2025.11.20-ны өдөр зохион байгуулж сургалтыг Монгол Улсын зөвлөх инженер, ХАБЭА-ийн сургагч багш Ч.Чинзориг болон барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Зөвшөөрлийн нэгдсэн систем license.mn цахим системээр хэрхэн авах тохиргоо зааварчилгааг МБҮА ТББ-ын мэргэжилтэн Г.Гантүвшин нар танилцууллаа.

МБҮА ТББ нь салбарын түншлэгч ТББ-уудтай хамтран ХББОСЯ-тай “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох” үйл ажиллагааг 5 дахь удаа гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн шинэ суурь нөхцөл, шаардлага болоод 2025.09.05-ны өдрөөс Зөвшөөрлийн нэгдсэн систем license.mn цахим системээр авдаг болсноор ААНБ, хуулийн этгээдүүдэд ямар өөрчлөлт бий болоод байгаа талаар танилцуулж нөхцөл шаардлагын талаарх мэдээллийг өглөө.


Мөн сургалтын дараагийн гол сэдэв болох барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ихэнх аж ахуйн нэгж, байгууллага нь ХАБЭА-н хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлдэггүй, ХАБЭА-н ажилтан, алба, хэлтсийг зохих орон тоогоор ажиллуулдаггүй, орон тооны тогтвортой ажилчид байхгүй, олон чиглэлээр түр зуурын туслан гүйцэтгэгч авч ажиллуулдаг, ХАБЭА-н урьдчилан арга хэмжээнд шаардлагатай хөрөнгө зардал гаргадаггүй, ХАБЭА-н менежментийн тогтолцоо нэвтрүүлдэггүй зэрэг нь энэ салбарт үйлдвэрлэлийн осол гарах, улмаар ажилтны амь нас, эрүүл мэнд хохирох үндсэн шалтгаан болж байгаа юм.



Иймд энэхүү сургалтаар барилгын салбарын ажлын онцлог, эрсдэлийн үнэлгээ, техник технологи, аюулгүй байдал нь ямар хууль, эрхзүйд нийцүүлсэн байх ёстой юм, барилгын салбарт хөдөлмөрийн аюулгүй байдлыг хэрхэн мөрдөж ажиллах вэ, ямар аюул эрсдэл учрах вэ, үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ, ямар хууль эрхзүйг баримтлан ажиллах вэ гэдгийг салбарын удирдах ажилтнууд болоод ИТА нарт хүргэлээ.

Сургалтын үеэр ХАБЭА-ийн олон улсын жишиг, стратеги төлөвлөлт, анхаарах талаар суралцагчид асууж өөрсдийн ажлын байр дээр гараад байгаа кейс, баримтыг хэрхэн шийдвэрлэх, юуг ажлын талбай дээрх осол гэж үзэх, хууль эрх зүйн хүрээнд ажилчдын аюулгүй байдлыг хэрхэн хангах, ажлын байр дээр осол эндэгдэл гаргахгүй байх тал дээр хэрхэн анхаарах зэргээр харилцан ярилцаж, мэргэжлийн багшаас зөвлөмж, зөвлөгөө авсан ач холбогдолтой сургалт боллоо.

МБҮА ТББ-иас **"ТУРШЛАГАА ХУВААЛЦЪЯ"** контентын энэ удаагийн дугаарыг Австрали улсын Куинсланд мужийн Вулгуру группд Төслийн менежерээр ажиллаж байгаа А.Эрбарын **МОНГОЛ УЛСАД ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ БУЮУ БАГА ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭТЭЙ БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**



Монгол Улсын эрчим хүчний салбар буюу Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-д дулааны тоолуур угсрагчаас инженер, Инженерийн албаны дарга хүртэл дэвшин ажиллахдаа дулааны хангамжийн систем, эрчим хүчний хэмнэлт, төслийн удирдлагын чиглэлээр өргөн мэдлэг, туршлага хуримтлуулсан Агиржавын Эрбар нь Австралийн Royal Melbourne Institute of Technology University (RMIT) буюу Мельбүрний Технологийн Их Сургуулийн Тогтвортой эрчим хүчний магистрийн хөтөлбөрийг 2021 онд Австралийн Засгийн газрын Australia Awards тэтгэлэгээр суралцаж төгссөн байна. Австралийн Засгийн газрын Australia Awards-ын мастерын сургалтын тэтгэлэгт хамрагдан сурсан мэргэжлээрээ амжилт гаргаж буй төгсөгчдийнхөө бүтээлийг нийтэлдэг ttps://australiaawardssouthasiamongolia.org сайтад нийтлэгдсэн А.Эрбарын тухай нийтлэлийг та бүхэндээ хүргэж байна.

Тэрээр RMIT-д суралцсан жилүүддээ сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, эрчим хүч хадгалах систем, тогтвортой барилгын гүйцэтгэлийн талаар гүнзгий мэдлэг олж авахаас гадна Австралийн өрхийн хэрэглээнд нарны эрчим хүч ашиглах хөтөлбөрийн туршлагыг судалж, 3.7 сая өрх аль хэдийн нарны цахилгаан системтэй болсон амжилт нь төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, бага чадлын нарны систем суурилуулах бизнесийг ухаалагаар дэмжсэн бодлого зэргээс суралцаж авчээ.

Гол нь өрхийн нарны систем нь цахилгаан хуримтлуургүйгээр хэт их суурилагдсанаас үүдэлтэй сүлжээний тогтворгүй байдал үүсэх, өдрийн цагаар илүүдэл эрчим хүчний үйлдвэрлэл бий болох зэрэг сөрөг үр дагаварыг Монголдоо давтахгүй байхыг сануулж байгаа юм.

“Монгол Улсад өрхийн нарны цахилгаан системийн хөгжил дөнгөж эхэлж байгаа тул Австралийн туршлагаас суралцан, эрэлт ба нийлүүлэлтийн тэнцвэртэй, төлөвлөгөөтэй хөгжлийг хэрэгжүүлэх том боломж юм” хэмээн Эрбар онцолжээ.

Австралид олж авсан мэдлэг туршлага дээр үндэслэн А.Эрбар нь Монгол улсын эрчим хүчний хуулийн шинэчлэлийн багт зөвлөхөөр ажиллаж “ӨРХИЙН НАРНЫ ЦАХИЛГААН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ БОДЛОГО-ын талаар танилцуулан хамтран ажиллаж байна. Энэхүү шинэчилсэн хууль хэрэгжвэл төрөөс айл өрх, аж ахуйн нэгжүүдийн эрчим хүч хуримтлуур бүхий нарны цахилгаан системийг урамшуулах, ухаалаг сүлжээ болон эрчим хүчний хэмнэлттэй сууцны шийдлийн уялдаа холбоог хангахад тодорхой дэвшил гарна гэж үзэж байгаа аж.

АЖЛЫН ТУРШЛАГА БА НИЙГМИЙН САНААЧИЛГА

Австралид суралцсаны дараа А.Эрбар “MCS International LLC”-ийн “Оюу Толгой” гүний уурхайн Хүдэр дамжуулах систем болон шугам сүлжээ суурилуулах төслийн барилгын Ахлах мэргэжилтэнээр ажиллаж, гүний уурхайн барилга угсралт, инженерчлэл, гүйцэтгэл, чанарын хяналтын тал дээр өргөн туршлага хуримтлуулжээ.

Тэрээр дулааны инженерийн хувьд бие даан суралцаж Олон улсын Мэргэшсэн Пассив Хаусын Зөвлөх/Дизайнер болсон ба өөрийн үүсгэн байгуулсан зөвлөх үйлчилгээний хүрээнд тэрээр Улаанбаатарын өвлийн хамгийн том агаарын бохирдлын шалтгаан болох нүүрсний зуухыг халж, эрчим хүч хэмнэлттэй, байгальд ээлтэй сууцыг хөгжүүлэхэд хувь нэмэрээ оруулахаар ажиллаж байна. Түүний зорилго бол нарны эрчим хүч, цахилгаан хуримтлуур, пассив хаусын зарчмыг нэгтгэсэн дэвшилтэт орон сууцны загварыг Монголд нутагшуулах явдал юм. “Нарны эрчим хүч, цахилгаан хуримтлуур, бага эрчим хүчний хэрэглээтэй барилгын зарчмыг хослуулснаар Монголын орон сууцны салбарт шинэ үеийг эхлүүлэх боломжтой. Энэ нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, барилгын дотоод орчны агаарын чанарыг сайжруулах, айл өрхийн

эрчим хүчний зардлыг бууруулах зэрэг чухал ач холбогдолтой шийдэл” гэж тэр хэлжээ.

ЗАЛУУСЫГ УРАМШУУЛАХ “ЗАЛУУ УДИРДАГЧИЙН ШАГНАЛ”-ЫГ ӨӨРӨӨ БИЙ БОЛГОСОН

2024 онд Эрбар анх ажлын гараагаа эхэлж 15 жил ажилласан байгууллага болох Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-д Young Leadership Award буюу “Залуу удирдагчийн шагнал”-ыг санаачлан бий болгосон ба энэхүү шагналыг жил бүр өөрийн зардлаар санхүүжүүлэх бөгөөд 35 хүртэл насны залуу ажилчин, инженер, менежерүүдийг хамрах ба баг удирдах чадвар, манлайлал, шинэлэг сэтгэлгээ болон өөрийгөө хөгжүүлэх чадвараар бусдаасаа ялгарсан ажилтнуудыг урамшуулах, тасралтгүй суралцах соёлыг дэмжих зорилготой юм.

Хэдийгээр тэр одоо тус компанид ажилладаггүй ч энэ санаачилгыг өөрийг нь төлөвшүүлж, мэргэжлийн замналынх нь үндэс болсон байгууллага болон хамт олондоо талархалаа илэрхийлэх нэгэн хэлбэр гэж үздэг.“Залуусыг дэмжих нь Монголын ирээдүйд оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт юм. Тогтвортой хөгжлийг хангахын тулд анхан шатны түвшинд хүчирхэг, шинэлэг удирдлагууд зайлшгүй хэрэгтэй” хэмээн тэр хэлжээ.

ИРЭЭДҮЙН ЗОРИЛГО- МОНГОЛД ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ БУЮУ БАГА ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭТЭЙ БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Австрали улсын Куинсланд мужийн Вулгуру группд Төслийн менежерээр ажиллаж байгаа А.Эрбарын урт хугацааны зорилго бол Монголд эрчим хүчний хэмнэлттэй буюу бага эрчим хүчний хэрэглээтэй барилгын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явдал юм. Тэрээр Австралийн нарны эрчим хүчний туршлага болон олон улсын пассив хаусын жишээн дээр тулгуурлан, төрөөс үзүүлэх оновчтой бодлого ба дэвшилтэт барилгын стандартуудыг хослуулах замаар уур амьсгалд ээлтэй, тогтвортой амины сууцны хөгжүүлэхийг зорьж байна.

https://australiaawardssouthasiamongolia.org/.../erbar.../












МБҮА ТББ НЬ ДАРХАН-УУЛ АЙМГИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДДЭЭ ГЭРЧИЛГЭЭГ ГАРДУУЛЛАА

хөгжлийн стратеги төлөвлөгөөний дагуу өөрийн гишүүд, салбарын ТББ-ууд болон Төрийн холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын эдийн засагт тохиолдсон удаа дараагийн хямрал, хүндрэлүүдийг даван туулахад салбарын дуу хоолой болон манлайлан ажиллаж Төр засгаар тодорхой шийдвэрүүд гаргуулж, үр дүнд нь зөвхөн гишүүдэд төдийгүй энэ салбарт ажиллаж буй нийт бизнес эрхлэгчдэд эерэг нөлөөллүүд бий болгож иржээ.

Монголын барилгын салбарын хөгжил, эрх зүйн орчныг сайжруулах, бизнес

эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь үндэсний барилгын компаниудын нэгдэл болохын хувьд нийслэл төдийгүй орон нутагт үйл ажиллагаагаа өргөжүүлж байгаа ба одоогийн байдлаар Баян-Өлгий, Ховд, Дархан-Уул аймгуудад салбар зөвлөлөө нээгээд байна.

Салбар зөвлөлүүд нь тухайн аймаг, орон нутгийн барилгын компаниудын эрх ашгийг хамгаалах, барилгын салбарын хөгжлийг дэмжих, шинэ технологи, стандартыг нэвтрүүлэх, боловсон хүчний чадавхыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах бөгөөд энэ удаагийн арга хэмжээнд Дархан-Уул аймгийн салбар зөвлөлийн дарга С.Дэлгэрбаяр тэргүүтэй Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Дархан-Уул аймгийн Барилгачдын холбоо, Монгол Алт ХК, Баян Бридж ХХК, Чуулгант ХХК, Минж Проперти ХХК, Эко ноос ХХК, Өрнөх Дэлгэр Констракшн ХХК, АНТО-ОД ХХК, КН Хийморь ХХК, Өсөх Урам ХХК, Түрэг Бридж ХХК-д Гишүүн байгууллага болсныг батламжилж Гэрчилгээг гардуулах арга хэмжээ боллоо.



https://www.facebook.com/share/v/1BuhBJPzve/









САЛБАРТАА МАНЛАЙЛАГЧ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМД ҮНЭ ЦЭНЭТЭЙ “CATALYST”-УУДЫН НЭГЭЭР МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН, MCS PROPERTY LLC НЬ ШАЛГАРЛАА



Энэ оны "Catalyst"-уудыг хөрөнгө оруулалт, инновац, тогтвортой хөгжил, дижитал шилжилт, манлайлал, төсөл зэрэг найман төрөлд шалгаруулсан бөгөөд **MCS Property LLC** нь “PROJECT CATALYST”-аар уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн бүтэцтэй МУ-д экспортын бүтээгдэхүүний төрөлжилт, валютын нөөцөд үнэмлэхүй хувь нэмэр оруулсан "Эрдэнэ Монгол" компаний Баянхөндий төслийг гүйцэтгэснээр шалгарсан байна. **MCS Property LLC**-ийн ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж, 26 сарын хугацаанд гүйцэтгэн хүлээлгэн өгсөн "Эрдэнэ Монгол" ХХК-ийн "Баянхөндий" төсөл нь Улаанбаатараас 1000 км зайд, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын говийн бүсэд хэрэгжсэн greenfield төрлийн стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалт юм. Төслийн хүрээнд боловсруулах үйлдвэр, ажилчдын амрах байрны цогцолбор, инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц байгууламжууд, үйлдвэрийн бус барилгуудыг цогцоор нь барьж байгуулсан бөгөөд энэ нь Монгол Улсын барилга угсралтын салбарын нэгэн жишиг бүтээн байгуулалт болсон юм.
МБҮА ТББ-ын Гишүүн, **MCS Property LLC**-ийн Нийт хамт олонд дахин баяр хүргэе.

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ, НОГООН САНХҮҮЖИЛТ, BESTGER АРГАЧЛАЛЫН ТАЛААР БАРИЛГЫН САЛБАРЫНХАНД ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ



Төрийн банк, Монголын Ногоон Барилгын Хүрээлэн НҮТББ, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ 2025.11.28-ны өдөр ногоон санхүүгийн боломж, ногоон барилгын үнэлгээ болох BestGer аргачлал, сэргээгдэх эрчим хүчний VII үеийн технологийн талаар барилгын салбарынханд танилцуулга хийлээ.



Уг арга хэмжээний үеэр Монгол улсад сэргээгдэх эрчим хүчний нөхцөл байдал, шилжилтийн талаар МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Эрчим инженеринг ХХК-ийн захирал М.Батболд, Төрийн банкны ногоон зээлийн бүтээгдэхүүн, танилцуулгыг Төрийн банкны Тогтвортой хөгжлийн албаны менежер А.Энх-Эрдэнэ, BestGER аргачлалын танилцуулгыг МНБХ ТББ-ын Гүйцэтгэх захирал Ц.Батгэрэл, BIPV Mongolia ХХК-ийн Ерөнхий захирал С.Болорбайгаль сэргээгдэх эрчим хүчний VII үеийн технологи нь Монгол Улсын барилгын салбарт нэвтэрч, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгож байгаа сонирхолтой танилцуулгуудыг хийлээ.
Мөн уг арга хэмжээний хүрээнд барилгын зураг төсөл болоод эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 50 гаруй компанийн төлөөллүүд үйл ажиллагаагаа танилцуулан

хамтран ажиллах боломж бололцоог эрэлхийллээ.





“ДУЛААН ШИЙДЭЛ-II” ТӨСЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

БАРИЛГЫН ДУЛААН АЛДАГДЛЫГ ТОДОРХОЙЛОХДОО ТӨРӨЛ БҮРИЙН БАГАЖ АШИГЛАЖ, ОЛОН ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ХАРГАЛЗАН ҮЗДЭГ



Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслийг хамтран хэрэгжүүлэгч МБҮА ТББ болон ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв (БЭХХТ) хамтран ***“Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ-дулааны камертай хэмжилтийн нэгдсэн дадлага сургуулилт”*** сэдэвт газар дээрх сургалтыг энэ сарын 2-нд зохион байгууллаа. Сургалтаар “Дулаан шийдэл II” төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчид болон МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагын төлөөлөл нь БЗД-ийн 2-р хороонд байрлах барилга/хувийн сууцанд дулаан алдагдал буй эсэхийг тодорхойлов. Аливаа барилгын дулаан алдагдлыг тодорхойлохдоо: Гадна, дотор агаарын температур, чийгшлийг хэмжиж, гадаргуугийн термометр ашиглахаас гадна хүйтний улиралд дулааны камераар үзлэг хийж болно гэдгийг сургалтыг удирдан явуулсан БЭХХТ-ийн захирал Б.Мөнхбаяр хэлсэн юм. Тодруулбал, дулааны камер давхар ашиглахын давуу тал нь барилгын нөхцөл байдлын хяналт, оношилгоог зайнаас хийж, асуудлыг эрт үед нь оношилсноор хариу арга хэмжээг аль болох хурдан авах шаардлагатайг баримтжуулан харуулдаг байна. Дулааны камераар гадна талаас дулааны зураглал нь тод шаргал өнгөтэй бол, дотор талаас цэнхэртэж харагдаж байвал

тэр хэсгээр дулаан алдагдалтай гэж ойлгогдоно. Дотор агаарын температур нь 20-22 градус, агаарын чийгшил 30-60 хувьтай байхыг зохистой гэж үздэг. Нөгөө талаас дотор агаарын температур 20 градусаас дээш, мөн агаарын чийгшил 20 хувиас их байвал агаар сэлгэлт шаардлагатай байдгийг нэмж тайлбарлалаа.

БАРИЛГЫН ДУЛААН ХАМГААЛАЛТ, ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТАЛААР ХОЁР ТӨРЛИЙН СУРГАЛТЫГ ДАРХАН-УУЛ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төсөл, түүнийг хамтран хэрэгжүүлэгч МБҮА ТББ-ын Төслийн багаас Дархан-Уул аймгийн барилгын салбарын ААНБ, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах хүрээнд 2025.11.09-нд төслийн хоёр сургалтдаа дээр дурдсан аймгийн давхардсан 30 гаруй бизнес эрхлэгч, салбарын төлөөллийг хамруулав. Сургалтуудад төсөлтэй хамтран ажилладаг Дарханы барилгын салбарын бизнес эрхлэгчид болон Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ, Дархан политехник коллеж, МБҮА ТББ-ын Дархан дахь салбар зөвлөлийн гишүүн Чуулгант ХХК зэрэг төлөөллүүд хамрагдсан юм. Төслөөс зохион байгуулсан өмнөх болон энэ удаагийн сургалтад идэвхтэй хамрагдсан, цаашид барилгын дулаалга, эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр ажиллах сонирхлоо илэрхийлсэн Дарханы оролцогчдодоо “Хөдөлмөрийн аюулгүй байдлын жишиг багц” олголоо.

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ХАЛААЛТЫН СИСТЕМ БА СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРҮҮД" СУРГАЛТ









"Эрчим хүчний хэмнэлттэй халаалтын систем ба сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд" сургалтаар, Барилгын дулаалга, битүүмжлэлийг сайжруулж, агаар сэлгэлтийн хэмнэлттэй шийдлийг ашиглан, түүнийгээ ухаалаг, зөв хэрэглэснээр халаалтын зардлыг хэд дахин бууруулах боломжтой төдийгүй сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах нь үр дүнтэй байдаг талаар оролцогчдод мэдлэг, мэдээлэл олгож, гарын авлагаар хангав.

“БАРИЛГЫН ДУЛААН ХАМГААЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ-ДУЛААНЫ КАМЕРТАЙ ХЭМЖИЛТИЙН НЭГДСЭН ДАДЛАГА СУРГУУЛИЛТ”




С“Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ-дулааны камертай хэмжилтийн нэгдсэн дадлага сургуулилт” сургалтаар, Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ хийхдээ эхлээд тухайн барилгын бүтээцийг зөв тодорхойлох, дулаалгатай эсэхийг нягтлах хэрэгтэй. Дулааны камераар зураг авахдаа, гадна болон дотор ханыг 4 талаас, хана болон хучилт, хана болон суурийн уулзварыг тус бүр, цонх болон хаалгыг ханын уулзварыг оруулан авч, гарсан зураглалд дүгнэлт хийнэ. Мөн гадна болон дотор агаарын температурын зөрүү, чийгшлийн хувь хэмжээ зэрэг үзүүлэлтээс шалтгаалж, барилгын дулаан алдагдал бий эсэхийг

1. Executive summary of the action

/Please provide an overview of the action's implementation on a yearly basis. Please describe the level of achievement referring to the project logical framework. To be filled annually/

SUB-PROJECT PROPOSAL DEVELOPED AND SUBMITTED TO THE KHAN BANK FOUNDATION





The Khan Bank Foundation, established in 2007 as the corporate social responsibility arm of Khan Bank, supports Mongolia's social and development initiatives. Since its inception, the Foundation has financed over 510 projects in areas such as healthcare, social investment, and climate protection, contributing more than 12.7 billion MNT to nationwide development efforts.

Given that the Foundation's priority areas are closely aligned with the objectives of the SOAP II project, the MNCA NGO Project Team prepared and submitted a sub-project proposal for co-funding. The proposal was developed in full compliance with the Foundation's submission guidelines, which can be accessed through the link below: https://www.khanbank.com/personal/about/corporate-social-responsibility/

Because Khan Bank incorporates its CSR-funded development initiatives into its annual sustainability reports and attracts international green financing, we considered the Foundation a relevant and promising partner. Additionally, the sub-project was designed in accordance with the '90/10 rule' introduced by Romain during the Economy-themed workshop in Tajikistan in October 2023. The proposal can be accessed through the link below: https://drive.google.com/drive/folders/15qFeI38C6nbdsPkYS9ZGXDF8YuJ2Bvq3?usp=drive_link

тогтоодог зэрэг мэдлэг мэдээлэл өгч, гарын авлагуудаар хангав.

ТӨСЛИЙН 4 ДҮГЭЭР ЖИЛИЙН 2 ДУГААР УЛИРАЛД БАРИЛГЫН САЛБАРЫН 60

SWITCH OFF AIR POLLUTION IN MONGOLIAN CITIES PROJECT

Funded by the Switch Asia II
Framework Programme of the European Union

ACA/2021/428/658

Quarterly report
01/08/2024- 31/10/2025

PROJECT	Switch Off Air Pollution in Mongolian cities
FUNDING	European Union (EU), SWITCH Asia II
COUNTRY	Mongolia
IMPLEMENTER	GERES (Group for Environment, Renewable Energy and Solidarity)
CO IMPLEMENTER 1	MUST (Mongolia University of Science and Technology) through BEEC (Building Energy Efficiency Centre)
CO IMPLEMENTER 2	MNCA (Mongolia National Construction Association)
CO IMPLEMENTER 3	MGFC (Mongolian Green Financing Corporation)
CO IMPLEMENTER 4	MONES (Mongolian Women's Fund)
REPORTING PERIOD	01/08/2025 - 31/10/2025

ОРЧИМ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛСАН БАЙНА

МБҮА ТББ-ын "Дулаан шийдэл II" төслийн баг нь 2025.08, 09, 10-р сард авч хэрэгжүүлсэн, хийж гүйцэтгэсэн ажлынхаа тайлан буюу төслийн 4 дүгээр жилийн 2 дугаар улирлын үйл ажиллагааны нарийвчилсан тайланг гарган, санхүүжүүлэгчдэд илгээв. Дээр дурдсан саруудад буюу төслийн өнгөрсөн улиралд, Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй "Дулаан шийдэл II" төслийг хамтран хэрэгжүүлэгчийн хувиар хийж гүйцэтгэсэн ажлаа тойм:


- Барилгын салбарын 60 орчим бизнес эрхлэгчийг барилгын дулаалгын технологи, эрчим хүч хэмнэлт, сэргээгдэх эрчим хүч, дулаалгын материалуудын шинж чанар, ногоон барилгын үнэлгээний аргачлал зэрэг чиглэлээр чадавхжуулж, дулаалгын ажлын практик дадлагад гаргасан байна.
- 123 хувийн сууцны буюу барилга/байшингийн дулаан алдагдлыг илрүүлэх ажилд 23 дулаалгын зөвлөхийг зуучилснаас 11 айл өрх хувийн санхүүжилт болон ногоон зээлээр дулаалгын ажил хийлгэсэн.
- Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын ажлын захиалга өгсөн хэрэглэгчдээс 58 хэрэглэгчийн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэлээ.
- Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын ажлаа хийж гүйцэтгэхэд нь зориулж 56 нэр төрлийн багаж, хэрэгслийг төсөлтэй хамтран ажилладаг дулаалгын зөвлөх болон МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагуудын төлөөлөлд олгосон байна.
- Төслийн санхүүжүүлэгчдийн өмнө хүлээсэн үүрэг болох 10 хувийн үлдэгдэл санхүүжилтээ өөрсдөө олох хүрээнд, "Барилгын салбарын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулан хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах нь" дэд төслийн санал боловсруулан, Хаан банк сан руу илгээж, санхүүжилт хүсэв. Энэхүү дэд төслийн саналаа МБҮА ТББ-ын 08-р сарын үйл ажиллагааны тайланд хавсаргаж, нийт гишүүддээ хүргэсэн болно.

- Барилгын салбарын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан төслийн гарын авлагыг дахин 100

- хувь хэвлүүлж, төслийн УБ болон Дархан-Уул аймаг дахь хамтрагчид руу хүргүүллээ.
- Гурав дахь жилдээ зохион байгуулсан “Спортын нөхөрсөг өдөрлөг”-т төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчид, МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагууд болон хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөллийг хамруулав.
- УБ болон Дархан-Уул аймагт явагдсан “Хялбар шийдэл” аяны дээврийн дулаалгын бригад зохицуулалтыг хариуцаж, нийтдээ 100 гаруй айл өрхөд дулаалга хийх ажилд төслийн бригадын ахлагчдыг холбон зуучиллаа.
- Барилга экспо-38 олон улсын барилгын үзэсгэлэнд оролцож, 1000 гаруй иргэнд барилгын дулаалга, эрчим хүч хэмнэлтийн ач холбогдлыг тайлбарлан таниулсан.
- Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан “Дулаан шийдэл II” төслийн Хөндлөнгийн зөвлөх хорооны хуралд оролцож, 2024.10-р сараас хойш тус аймагт хийж хэрэгжүүлсэн Төслийн багийн ажлуудаа танилцуулж, оролцогчдын асуултад хариулав.
- МБҮА ТББ-ын Гишүүн байгууллага болох Бодь Пропертийз ХХК-ийн санхүүжилтээр, “Дулаан шийдэл II” төслийн хүрээнд дулаалсан хоёр айл өрхийн байшинд халаалтын систем, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж суурилуулах ажлын явцтай танилцлаа.

Та бүхэн төслийг удирдан хэрэгжүүлэгч Жэрэс ОУТББ-аар дамжуулан, төслийг санхүүжүүлэгч Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөр рүү илгээсэн МБҮА ТББ-ын "Дулаан шийдэл II төслийн багийн 4 дүгээр жилийн 2 дугаар улирлын үйл ажиллагааны тайлан”-тай доорх холбоосоор танилцах боломжтой.
https://drive.google.com/file/d/1WQaVn8XBjzlhbDNZJlUFh8lyEvNDTXys/view?usp=drive_link

“ХААН БАНК”-НЫ ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗАЛТ ХИЙВ



МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

ХААН БАНК САНД

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ
Монгол Улс, Улаанбаатар 15141, Чингэлтэй дүүрэг,
5 дугаар хороо, Самбуугийн гудамж 24,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот
Утас: + (976) 7011 1515
И-мэйл: info@mnca.mn, Веб: www.mnca.mn

2025.08.25 №25/114/АА

Танай -ны №-т

Төслийн санал илгээх тухай

Эрхэм Таны энэ өдрийн амар амгаланг айлтгаж, ажил үйлсэд нь амжилт хүсэн мэндчилье.

Манай байгууллага нь 2018 оноос хойш Европын холбооны Свич-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй Дулаан шийдэл I, II төслийг Жэрэс ОУТББ, ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв, Пипл ин Нийд ОУТББ, Монголын ногоон санхүүгийн корпораци, Монголын эмэгтэйчүүдийн сантай хамтран хэрэгжүүлж ирлээ.

Төслийн үр дүнд, одоогийн байдлаар 241 барилгын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч (БЖДБЭ)-дийг барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалга болон бусад чиглэлээр чадавхжуулан, 3308 айл өрхийг дулаалсны үндсэн дээр хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, агаарын бохирдлыг бууруулахад бодит хувь нэмрээ оруулж байгаа юм.

Төслийн нэгдүгээр үе шатыг Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн сууцыг дулаалж, дулаан алдагдлыг багасгаснаар агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготойгоор 2018-2022 онд хэрэгжүүлсэн. Төслийн хоёрдугаар үе шатанд үйл ажиллагаагаа улам өргөжүүлэзд байгаа бөгөөд Монголын нөхцөлд нийцсэн, үр ашигтай эрчим хүчний шийдлүүдийг боловсруулан нэвтрүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулан, эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн хувьд үр ашигтай байх зах зээлийг бий болгох зорилготойгоор 2022-2026 онд хэрэгжүүлж байгаа болно.

Дулаан шийдэл II төслийг хамтран хэрэгжүүлэгчид нь Европын холбооны Свич-Эшиа хөтөлбөр тэргүүтэй гадны санхүүжүүлэгчдээс 90 хувийн санхүүжилт татсан. Үлдсэн 10 хувийн санхүүжилтээ хамтын санхүүжилт хэлбэрээр өөрсдөө олох үүрэг хүлээж байгаа юм.

Өнгөрсөн хугацаанд манай байгууллага Дулаан шийдэл II төслийг хамтран хэрэгжүүлэгчийн хувиар **Бодь групп/Бодь пропертийз ХХК болон Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газраас зарласан төсөл сонгон шалгаруулалтад зориулан дэд төслүүд боловсруулан шалгарч, тодорхой хэмжээний хамтын санхүүжилт татан, эдгээр дэд төслийг амжилттай хэрэгжүүлж, санхүүжүүлэгчдэд үр дүнгээ хүлээлгэн өгөөд байна.**

Энэ удаад манай байгууллага **“Барилгын салбарын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулан хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах нь”** дэд төслийн санал боловсруулан Та бүхэнд илгээлээ.

Энэхүү төслийн саналтай танилцаж, хамтран ажиллахыг хичээнгүйлэн хүсэж байна.

Хамтын ажиллагаанд талархав.

10 хавсралт, 314 хуудас

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.БАТСҮХ

МБҮА ТББ-ын 8-р сарын тайланд дурдсанчлан, Хаан банк сан руу дэд төслийн санал боловсруулж, хамтын санхүүжилт хүсэж байгаагаа мэдээлж байсны дагуу тус банкны холбогдох хүмүүстэй 2025.11.4-нд хамтарсан уулзалт хийв. Уулзалтаар МБҮА ТББ нь “Дулаан шийдэл II” төслийг хамтран хэрэгжүүлэгчийн хувиар хийж гүйцэтгэдэг дараах үйл ажиллагаа, арга хэмжээг тодорхой дүнгээр бүхэлд нь эсвэл хэсэгчлэн, мөн аль нэгийг сонгон хамтын санхүүжилт олгох боломжтой эсэх талаар хэлцэл өрнүүлсэн. Үүнд:

- Барилгын салбарын БЖДБЭ-ийг

гүнзгийрүүлэн чадавхжуулахад: 20,8

сая төгрөг
- Гүнзгийрүүлж чадавхжуулсан БЖДБЭ-чдийг барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалгын ач холбогдлын талаар айл өрхүүдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх, дулаалгын ажилд зуучлахад: 15 сая төгрөг
- Ажилд зуучилж буй БЖДБЭ-чдийн гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор барилгын багаж, хамгаалах хэрэгслээр хангах, урамшуулахад: 15 сая төгрөг
- Хамтран ажиллаж буй БЖДБЭ-чдийн цаашдын тогтвортой байдал хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, сурталчлан таниулах, борлуулалтыг нь нэмэгдүүлэх зорилгоор арга хэмжээнүүд зохион байгуулахад: 16,2 сая төгрөгийг хүсэв.

Уулзалтын үр дүнд Хаан банк нь банкны ажилчдадаа төслийн дулаалгын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, Хаан банк Академиас зохион байгуулдаг чадавхжуулах хөтөлбөртөө төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчдийг хамруулах, иргэдэд барилгын эрчим хүч хэмнэлтийн талаар мэдээлэл өгөх хамтарсан өдөрлөг зохион байгуулах зэрэг чиглэлд хамтран ажиллах боломжтой гэв. Ийнхүү хоёр тал цаашид хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр тогтлоо.

Хаан банк сан нь 2007 онд байгуулагдсан бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлж буй хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд санхүүжилт олгосоор ирсэн. Тус сан байгуулагдсанаасаа хойш манай улсын эрүүл мэнд, нийгэм, уур амьсгалын өөрчлөлт зэрэг чиглэлийн 510 төсөлд 12,7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байдаг. Сангийн тэргүүлэх чиглэлүүд нь “Дулаан шийдэл II” төслийн зорилго, зорилтуудтай нийцэж байгаа тул бид үлдэгдэл хамтын санхүүжилтээ олох зорилгоор Дэд төслийн санал боловсруулж, хүргүүлсэн нь энэ юм. Дэд төслийн саналаа боловсруулахдаа, тус сангийн төслийн сонгон шалгаруулалтын удирдамжийн дагуу боловсруулсан бөгөөд доорх холбоосоор нэвтэрч үзэх боломжтой: https://www.khanbank.com/personal/about/corporate-social-responsibility/

Хаан банк, Хаан банк сан нь тухайн жилийн санхүүжилт олгосон төсөл, хөтөлбөрийнхөө талаар “Тогтвортой хөгжил ба БОНЗ-ын тайлан”-даа дурддаг ба олон улсаас ногоон санхүүжилт татдаг, төсөлтэй хамтран ажилладагаас гадна тус сангийн тэргүүлэх чиглэл нь төслийн зорилго, зорилтуудтай нийцэж байсан учир санхүүжилт хүссэн юм. Мөн нэг зүйлийг онцлоход, 2023.10-р сард Тажикистан улсад болсон “Дулаан шийдэл төслийн оролцогч талуудын эдийн засгийн уулзалт”-аар яригдсан “Бидэнд 90 хувийн санхүүжилт нь байна, үлдсэн 10 хувийг хамтран санхүүжүүлнэ үү” гэсэн зарчмаар дэд төслийн саналаа боловсруулсан юм. Энэхүү дэд төслийн саналтай Та бүхэн танилцаад, төслийн багтай холбогдон, бидэнд хамтын санхүүжилт олгон, агаарын бохирдлыг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, тэр дундаа барилгын салбарт үйл ажиллагаагаа явуулж буй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулан хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах үйлсэд хамтран ажиллахыг үүгээр дахин уриалж байна.

Дэд төслийн санал болон хавсралтуудтай танилцах холбоос:
https://drive.google.com/drive/folders/15gFeI38C6nbdsPkYS9ZGXDF8YuJ2Bvg3?usp=drive_link

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН БАГИЙН 2025.11-Р САРЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ

Д/д	Үйл ажиллагаа	Тоон үзүүлэлт
1.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	9
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	7
3.	Барилгын салбарын БЖДБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	6
4.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	3
5.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	45
6.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	15
7.	Санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн айл өрхийн тоо	8



МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn